



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 8/97

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Өсвөр үеийн эрүүл мэндийн тандалтын журам”-ыг нэгдүгээр, “Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийн маягт”-ыг хоёрдугаар, Сэтгэлзүйчийн тусlamж “Үйлчилгээний маягт”-ыг гуравдугаар, “Нийгмийн ажилтны тусlamж үйлчилгээний маягт”, “Урьдчилан сэргийлэх үзлэг”, “Зөвлөгөө авагчдын бүртгэл”-ийг дөрөвдүгээр, “Өсвөр үеийн эрүүл мэндтэй холбоотой нэр томъёоны тодорхойлолт, тайлбар”-ыг тавдугаар, “Өсвөр үеийн эрүүл мэндийн тандалтын мэдээллийн урсгал”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Шинэчлэгдсэн журмыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга, эрхлэгч наарт үүрэг болгосугай.
- Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буяントогтох/-д, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д, Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл /Б.Цэдмаа/-д, Хүүхдийн мэргэжлийн салбар зөвлөлд (Б.Баясгалантай)-д тус тус даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.
- Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэнд, спортын сайдын “Өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийн маягт батлах тухай” 2015 оны 224 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

С.ЭНХБОЛД



Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 06 сарын 16 өдрийн хял  
тушаалын нэгдүгээр хавсралт

## ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Өсвөр үеийн эрүүл мэндийн тандалтын тогтолцоо /Цаашид Тандалтын тогтолцоо гэх/ гэж өсвөр үеийн эрүүл мэндтэй холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулах, нэгтгэх, дамжуулах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, нотолгоонд үндэслэсэн шийдвэр гаргах цогц үйл ажиллагааг хэлнэ.
- 1.2. Тандалтын тогтолцоогоор өсвөр үеийн эрүүл мэндийн талаарх мэдээ, мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулна.
- 1.3. Бүх шатны улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь өсвөр үеийн эрүүл мэндийн тандалт, эрт сээрэмжлүүлэг, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомж, тушаал, журам, стандартыг дагаж мөрднө.

### Хоёр. Мэдээний төрөл, давтамж

#### 2.1. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлт

- 2.1.1. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийг өдөр бүр батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлнэ.

#### 2.2. Сэтгэлзүйчийн тусламж үйлчилгээ

- 2.2.1. Сэтгэлзүйчийн үзлэгийг өдөр бүр батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлнэ.

#### 2.3. Нийгмийн ажилтны тусламж үйлчилгээ

- 2.3.1. Нийгмийн ажилтны тусламж үйлчилгээг өдөр бүр батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлнэ.

#### 2.4. Урьдчилан сэргийлэх үзлэг

- 2.4.1. Урьдчилан сэргийлэх үзлэгийг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах бүрт батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлнэ.

#### 2.5. Зөвлөгөө авагчдын бүртгэл

- 2.5.1. Зөвлөгөө авсан хүүхэд (үзлэг, шинжилгээ хийгдээгүй, зөвхөн зөвлөгөө авсан тохиолдол) бүрийг батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлнэ.

## **2.6. Тохиолдлын тоо**

2.6.1. Батлагдсан маягтын дагуу тоон мэдээг нэгтгэн дараа сарын эхний долоо хоногт цахим хэлбэрээр мэдээлнэ.

### **Гурав. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн гүйцэтгэх үүрэг**

3.1. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь үндэсний түвшинд өсвөр үеийн эрүүл мэндтэй холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, нотолгоонд үндэслэсэн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллана.

3.2. Тандалт судалгааны алба нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.2.1. Үндэсний түвшинд тандалтын мэдээ, мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх зорилгоор зөвшөөрөгдсөн программ хангамж, цахим хаягтай байх бөгөөд программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

3.2.2. Улирал бүр мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

3.2.3. Өсвөр үеийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар бусад мэдээллийн эх сурвалжийг ашиглах, шаардлагатай гэж үзвэл холбогдох эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээлэл гаргуулах, эсвэл тусгайлсан судалгаа хийж, нотолгоо, зөвлөмж, дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

3.2.4. Эрүүл мэндийн байгууллагуудын өсвөр үеийн эрүүл мэндийн тандалтын бүртгэл, тайлан мэдээнд хяналт, үнэлгээ хийж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.2.5. Үндэсний түвшинд өсвөр үеийн эрүүл мэндийн тандалтын чиглэлээр сургалт, семинар зохион байгуулна.

3.2.6. Үндэсний түвшинд өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байдалд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба хяналт тавьж ажиллана.

### **Дөрөв. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын гүйцэтгэх үүрэг**

4.1. Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь харьяа эрүүл мэндийн байгууллагуудын өсвөр үеийн эрүүл мэндтэй холбоотой тандалтын бүртгэл, тайлан мэдээний үнэн зөв, бүрэн гүйцэд, шуурхай байдалд улирал тутам хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

### **Тав. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн гүйцэтгэх үүрэг**

5.1. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллүүдийг батлагдсан маягтын дагуу журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5-д зааснаар өдөр бүр цахимаар мэдээлнэ.

5.2. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар тохиолдлын тоог сар бүр нэгтгэн, дараа сарын эхний 7 хоногт цахимаар мэдээлнэ.

5.3. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийн үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байдалд тасгийн эрхлэгч, Эрүүл

мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга, менежер нар хяналт тавьж ажиллана.

### **Зургаа. Дүүргийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэх үүрэг**

- 6.1. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллүүдийг батлагдсан маягтын дагуу журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5-д зааснаар өдөр бүр цахимаар мэдээлнэ.
- 6.2. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар тохиолдлын тоог сар бүр нэгтгэн, дараа сарын эхний 7 хоногт цахимаар мэдээлнэ.
- 6.3. Дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийн үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байдалд хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга, менежер нар хяналт тавьж ажиллана.

### **Долоо. Сумын эрүүл мэндийн төвийн гүйцэтгэх үүрэг**

- 7.1. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллүүдийг батлагдсан маягтын дагуу журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5-д зааснаар өдөр бүр цахимаар мэдээлнэ.
- 7.2. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар тохиолдлын тоог сар бүр нэгтгэн, дараа сарын эхний 7 хоногт цахимаар мэдээлнэ.
- 7.3. Сумын эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийн үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байдалд сумын эрүүл мэндийн төвийн дарга, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны менежер нар хяналт тавьж ажиллана.

### **Найм. Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн төвийн гүйцэтгэх үүрэг**

- 8.1. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллүүдийг батлагдсан маягтын дагуу журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5-д зааснаар өдөр бүр цахимаар мэдээлнэ.
- 8.2. Өсвөр үеийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, зөвлөгч/сувилагч нар тохиолдлын тоог сар бүр нэгтгэн, дараа сарын эхний 7 хоногт цахимаар мэдээлнэ.
- 8.3. Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийн үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байдалд тасгийн эрхлэгч, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга, менежер нар хяналт тавьж ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 26 сарын 26 өдрийн 10:00-т  
тушаалын хоёрдугаар хавсралт

## ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН МАЯГТ

### 1. Ерөнхий асуулга

1. Мэдээлсэн газар: Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Эрүүл мэндийн байгууллагын нэр \_\_\_\_\_
2. Үзлэг: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр
3. Регистрийн дугаар:
4. Нас:
5. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй 3. Бусад
6. Үндсэн хаяг: Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_
7. Энд ирэхийг хэн санал болгосон бэ?  
1. Өөрийн хүсэлтээр  
2. Гэр бүлийнхний хүсэлтээр  
3. Үе тэнгийнхний зөвлөснөөр  
4. Бусад эмнэлэг, эмч илгээсэн  
5. Бусад байгууллагаас (эмнэлгээс бусад) илгээсэн
8. Хөдөлмөр эрхэлдэг эсэх: 1. Тийм 2. Үгүй
9. Суралцдаг эсэх: 1. Тийм 2. Үгүй  
Хэрэв тийм бол ямар сургуульд сурдаг вэ?  
1. Ерөнхий боловсролын сургууль  
2. Их, дээд сургууль, коллеж  
3. Политехник коллеж, МСҮТ  
4. Насан туршийн ба албан бус боловсролын сургалт  
5. Мэргэжил эзэмших, мэргэшил дээшлүүлэх сургалт, бусад

### 2. Асуумж/анамнез

10. Өмнө нь жирэмсэлж байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй  
Тийм бол хэдэн удаа:
- Өмнө нь үр хөндөлт хийлгэж байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй
- Өмнө нь төрж байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй  
Төрж байсан бол хэдэн удаа:
11. Өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан уу? 1. Тийм 2. Үгүй  
Тийм бол ямар БЗДХ-аар өвдөж байсан бэ?  
1. Тэмбүү  
2. Заг хүйтэн  
3. Трихомониаз  
4. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_
- БЗДХ-аар өвдөж байсан бол эмчлүүлж байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй
12. Ямар нэгэн хорт зуршилтай эсэх: 1. Тийм 2. Үгүй  
Тийм бол ямар хорт зуршилтай вэ?  
1. Мансууруулах төрлийн бодис  
2. Тамхи  
3. Архи, согтууруулах ундаа

4. Компьютер, утсанд донтсон  
5. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_
13. Өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй  
Тийм бол ямар төрлийн хүчирхийлэлд вэ?

1. Бэлгийн
2. Бие махбодийн
3. Сэтгэл санааны
4. Үл хайхрах
5. Гэр бүлийн
6. Бусад

Хүчирхийлэлд өртсөн орчин:

1. Гэр бүл
2. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

14. Өмнө нь сэтгэцийн эмгэг оношлогдож байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй  
15. Өмнө нь осол, гэмтэлд өртөж байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй

### 3. Үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудал / бодит үзлэгээр/

16. Биеийн жин  .  кг

17. Биеийн өндөр  .  см

18. Бэлгийн бойжилтын үнэлгээ:

Эрэгтэй:

Төмсөгний хөгжил:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Умдагны үсжилт:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Гинекомастия 1. Тийм 2. Үгүй

Эмэгтэй:

Хөхний хөгжил:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Умдагны үсжилт:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Биений юм:

1. Me<sub>0</sub>
2. Me<sub>1</sub>

3.  $Me_2$

Тодорхойгүй:

Төмсөгний хөгжил:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Умдагны үсжилт:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Хөхний хөгжил:

1. Tanner I
2. Tanner II
3. Tanner III
4. Tanner IV
5. Tanner V

Биений юм:

1.  $Me_0$
2.  $Me_1$
3.  $Me_2$

19. Жирэмсэн эсэх (сорил, шинжилгээгээр батлагдсан байх):

1. Тийм

2. Үгүй

Тийм бол жирэмснийг хэрхэн шийдвэрлэсэн бэ?

1. Зөвлөгөө
2. Шилжүүлсэн
3. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

20. БЗДХ оношлогдсон эсэх (сорил, шинжилгээгээр батлагдсан байх):

1. Тийм
2. Үгүй

Тийм бол ямар БЗДХ оношлогдсон бэ?

1. Тэмбүү
2. Заг хүйтэн
3. Трихомониаз
4. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

БЗДХ-ын менежмент:

1. Зөвлөгөө
2. Эмчилгээ
3. Шилжүүлсэн
4. Давтан үзлэг/шинжилгээ товлосон
5. Давтан эмчилгээ/хяналт

21. Гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгсөн эсэх:

1. Тийм

2. Үгүй

22. Нийгэм/сэтгээүйн асуудалтай эсэх

1. Тийм
2. Үгүй

Тийм бол ямар менежмент хийсэн бэ?:

1. Зөвлөгөө өгсөн
2. Мэдээлсэн
3. Шилжүүлсэн
4. Давтан цаг товлосон
5. Нийгмийн ажилтан/сэтгэлзүйчид холбосон

23. Хүчирхийлэлд өртсөн, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй эсэх:

1. Тийм      2. Үгүй

Тийм бол ямар төрлийн хүчирхийлэлд вэ?

1. Бэлгийн
2. Бие махбодийн
3. Сэтгэл санааны
4. Үл хайхрах
5. Гэр бүлийн
6. Бусад

Хүчирхийлэлд өртсөн орчин:

1. Гэр бүл
2. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

Хүчирхийлэлд өртсөн, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй бол ямар менежмент хийсэн бэ?

1. Зөвлөгөө өгсөн
2. Мэдээлсэн
3. Шилжүүлсэн
4. Давтан цаг товлосон
5. Нийгмийн ажилтан/сэтгэлзүйчид холбосон
6. Бусад \_\_\_\_\_

24. Онош (дэлгэрэнгүй эсвэл олон улсын өвний ангиллын кодоор бичнэ үү):

Үндсэн онош: \_\_\_\_\_

Хүндрэл: \_\_\_\_\_

Хавсарсан онош: \_\_\_\_\_

#### Тохиолдлын тоо

1. Өсвөр үеийн кабинет, клиникээр үйлчлүүлсэн хүүхэд, өсвөр насыхан, залуучуудын тоо:

1. 10-аас доош нас: \_\_\_\_\_
2. 10-19 нас: \_\_\_\_\_
3. 20-24 нас: \_\_\_\_\_

2. Зөвлөгөө авсан хүүхэд, өсвөр насыхан, залуучуудын тоо:

3. Сэтгэлзүйчийн тусlamж үйлчилгээ авсан хүүхэд, өсвөр насыхан, залуучуудын тоо:

4. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны тусlamж үйлчилгээ авсан хүүхэд, өсвөр насыхан, залуучуудын тоо:

5. Өсвөр үеийнхэн, залуучуудын эрүүл мэндийн чиглэлээр тэдэнд зохион байгуулсан сургалтын тоо:

6. Эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан сургалтанд хамрагдсан хүний тоо:

7. Эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо:

8. Өсвөр үеийн эрүүл мэндийн баримжаа олгох сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо

9. Өсвөр үеийн эрүүл мэндийн төрөлжсөн тусlamж үйлчилгээний сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо: \_\_\_\_\_

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 08 сарын 26 өдрийн 14:00 тоот  
тушаалын гуравдугаар хавсралт

## СЭТГЭЛЗҮЙЧИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАЯГТ

1. Тусlamж үйлчилгээ үзүүлж эхэлсэн: \_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр \_\_\_ цаг \_\_\_ минут

2. Хүйс: 1. Эмэгтэй 2. Эрэгтэй 3. Бусад

3. Регистрийн дугаар: \_\_\_\_\_

4. Нас:

5. Үндсэн хаяг: Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_

6. Одоо оршин суугаа хаяг: Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_

7. Энд ирэхийг хэн санал болгосон:

1. Дүүргийн эрүүл мэндийн төв

2. Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс

3. Аймгийн Нэгдсэн эмнэлэг

4. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс

5. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

6. Хувийн сэтгэлзүйн төв

7. Өөрсдөө ирсэн

8. Найз нөхөд зөвлөсөн

9. Гэр бүлийн хүснэлтээр

10. ЭХЭМҮТ (тасгийг бичнэ үү) \_\_\_\_\_

11. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

8. Сурдаг эсэх: 1. Тийм 2. Үгүй

Хэрэв тийм бол сургуулийн нэр/дугаар, анги .....

Хэрэв үгүй бол шалтгааныг бичнэ үү (хэддүгээр ангиасаа завардсан, шалтгаан) .....

9. Хөдөлмөр эрхэлдэг эсэх: 1. Тийм 2. Үгүй

10. Хэрэв тийм бол ямар хөдөлмөр эрхэлдэг талаар бичнэ үү

11. Өмнө нь сэтгэлзүйн тусlamж үйлчилгээ авч байсан эсэх: 1. Тийм 2. Үгүй

Тийм бол хаанаас тусlamж үйлчилгээ авч байсан бэ?

12. Хэнтэй хамт амьдардаг:

1. Аав 2. Ээж 3. Хойд аав 4. Хойд ээж 5. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

13. Гэр бүлийн дэмжлэг хэр вэ?

Сэтгэл зүйн дэмжлэг:

1. Сайн 2. Дунд 3. Муу

Эдийн засгийн дэмжлэг:

1. Сайн 2. Дунд 3. Муу

14. Хандсан асуудал:

1. Хүчирхийлэл

5. Сэтгэлзүйн тулгамдсан асуудал

2. Жирэмслэлт

6. Сайн дүрын сэтгэлзүйн зөвлөгөө

3. Гэр бүлийн асуудал

7. Бие сэтгэцийн хавсарсан асуудал

4. Амиа хорлох бодол, оролдлого

8. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

Хэрэв хүчирхийллийн асуудлаар ирсэн бол төрлийг сонгоно уу

Хүүхдийн эсрэг: 1. Бэлгийн 2.Бие махбодын 3.Сэтгэлзүйн 4.Ул хайхрах  
Гэр бүлийн .....  
Сэтгэлзүйн тулгамдсан асуудал

- |  |  |                                 |
|--|--|---------------------------------|
| Сэтгэл хөдлөл:   | 1.Сэтгэл түгших байдал                                   | 4.Сэтгэл хэт хөөрөх байдал      |
|  | 2.Сэтгэл гутралын байдал                                 | 5. Айдсын байдал                |
|  | 3.Үүр бухимдал   | 6.Бусад (нэрлэж бичнэ үү) _____ |
| Танин мэдэхүй  | 1.Анхаарал төвлөрөл сулрах, ой тогтоолт муудах           |                                 |
|  | 2. Оюун ухааны хөгжлийн түвшин                           |                                 |
|  | 3.Хэл ярианы өөрчлөлт                                    |                                 |
|  | 4.Бусад (нэрлэж бичнэ үү)                                |                                 |
| Зан үйл  | 1. Амия хорлох бодол санаа төрдөг                        |                                 |
|  | 2. Амия хорлох оролдлого хийсэн                          |                                 |
|  | 3. Хооллох дур хүсэлтэй холбоотой өөрчлөлт               |                                 |
|  | 4. Дэлгэцийн хамаарал /компьютер, зурагт, гар утас/      |                                 |
| Хорт зуршил  | 1.Архины хэрэглээ  |                                 |
|  | 2.Тамхины хэрэглээ                                       |                                 |
|  | 3.Мансууруулах төрлийн бодисын хэрэглээ                  |                                 |
|  | 4.Бусад (нэрлэж бичнэ үү)                                |                                 |
| Харилцаа   | 1. Гэр бүлийн тааламжгүй байдал                          |                                 |
|  | 2. Найз нөхөд, анги, хамт олонтойгоо ойлголцохгүй байдал |                                 |
|  | 3. Багш, сургуулийн ажилчдын тааламжгүй харилцаа         |                                 |
|  | 4. Өөрийгөө хэт буруутгах                                |                                 |
|  | 5. Бусдыг хэт буруутгах                                  |                                 |
|  | 6. Бусад (нэрлэж бичнэ үү) _____                         |                                 |
| 15. Үйлчлүүлэгчид үзүүлсэн сэтгэлзүйн тусламж үйлчилгээ                        |  |                                 |
|  | 1. Сэтгэлзүйн зөвлөгөө                                   |                                 |
|  | 2. Сэтгэл засал  |                                 |
|  | 3. Сэтгэл зүйн оношлогоо                                 |                                 |
|  | 4. Сэтгэл зүйн сургалт                                   |                                 |
|  | 5. Гэр бүлийн зөвлөгөө                                   |                                 |
|  | 6. Бүлгийн зөвлөгөө                                      |                                 |
|  | 7. Бусад (нэрлэж бичнэ үү) _____                         |                                 |
| Гэр бүлийн зөвлөгөөнд хамрагдсан хүний тоо:                                    |  |                                 |
| Гэр бүлийн ямар гишүүддэд зөвлөгөө өгсөн бэ?                                   |  |                                 |
| 1.Аав 2.Ээж 3.Эмээ 4.Өвөө 5.Ах 6.Эгч 7.Бусад ( нэрлэж бичнэ үү)                |  |                                 |
| 16. Зөвлөгөөний цаашдын төлөвлөгөө:  |  |                                 |
| 1.Үйлчилгээг төгсгөх   |  |                                 |
| 2.Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үргэлжилж байгаа                               |  |                                 |
| 3.СЭМҮТ-д холбон зуучилсан   |  |                                 |
| 4.Бусад _____  |  |                                 |
| 16. Үйлчилгээг төгсгөсөн огноо: ____ он ____ сар ____ өдөр ____ цаг ____ минут |  |                                 |
| 17. Нийт зөвлөгөөний тоо: ____   |  |                                 |
| 18. Нийт уулзалтын тоо: ____   |  |                                 |

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 24 сарын 16 өдрийн 14 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

## НИЙГМИЙН АЖИЛТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАЯГТ

- Үзлэг эхэлсэн: \_\_\_\_ он \_\_ сар \_\_ өдөр \_\_ цаг \_\_ минут
  - Үйлчлүүлэгчийн овог.....
  - Үйлчлүүлэгчийн нэр.....
  - Регистрийн дугаар:
  - Нас:
  - Хүйс:      1. Эмэгтэй      2. Эрэгтэй      3. Бусад
  - Үндсэн хаяг:      Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_
  - Одоо оршин суугаа хаяг:      Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_

#### 11. Энд ирэхийг хэн санал болгосон

1. Өөрийн хүсэлтээр
  2. Асран хамгаалагчийн санаачлагаар
  3. Хүүхэд хамгааллын байгууллагаас холбосон
  4. Бусад шатлалын эмнэлгээс илгээсэн
  5. Хувийн эмнэлгээс илгээсэн
  6. ЭХЭМҮТ (тасгийг сонгоно уу) \_\_\_\_\_
  7. Бусад (нэрлэж бичнэ уу) \_\_\_\_\_

12. Суралцдаг эсэх: 1.Тийм 2.Үгүй

Хэрэв тийм бол сургуулийн нэр/дугаар, анги:

Хэрэв угүй бол шалтгааныг бична уу (хэлдүгээр аngiасаа засварласан шалтгаан):

13. Хөдөлмөр эрхэлдэг эсэх: 1 Тийм 2 Үүгүй

Хэрэв тийм бол ямар хөдөлмөр эрхээдэг тадаар бична уу

#### 14. Ам булийн тоо:

#### 15. Хэнтэй хамт амьдардаг

1. Аав    2. Ээж    3. Хойд аав    4. Хойд ээж    5. Бусад (нэрлэж бичнэ үү)

16. Гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бичнэ уу

- .....
17. Эцэг эхээс өөр хүн асран хамгаалдаг эсэх: 1.Тийм 2. Үгүй  
18. Тийм бол тухайн хүний хэн болохыг бичнэ үү
- .....

19. Ямар байр/гэрт амьдардаг вэ?  
1. Төвийн халаалттай орон сууц  
2. Гэрийн хорооллын байшин  
3. Гэр хороолол монгол гэрт  
4. Гэр хорооллын нийтийн байр  
5. Дотуур байр  
6. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

20. Одоо амьдарч буй байр/гэр хэнийх вэ?

1. Θөрийн  
2. Хамаатны  
3. Түрээсийн  
4. Сургуулийн дотуур байр  
5. Түр хамгаалах байр  
6. Халамжийн төв  
7. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

21. Нийгмийн ажилтанд анх/ давтан хандаж буй эсэх:

1. Анх удаа  
2. Хоёр ба түүнээс олон удаа бол (тоог бичнэ үү) \_\_\_\_\_

22. Хэн нэгэнтэй хамт ирсэн эсэх: 1.Тийм 2. Үгүй

Тийм бол хэнтэй хамт ирсэн:

1. Аав 2. Ээж 3.Эгч 4.Aх 5.Багш 6.Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

23. Хандах болсон шалтгаан:

- |                  |   |
|------------------|---|
| 1. Хүчирхийлэл   | 5. Гэр бүлийн гишүүдийн таарамжгүй байдал |
| 2. Жирэмслэлт    | 6. Ye тэнгийнхний дарамт, шахалт          |
| 3. БЗДХ          | 7. Нийгмийн халамжийн тусламж авах        |
| 4. Гэрээс дайжих | 8. Бусад (нэрлэж бичнэ үү) _____          |

24. Үйлчлүүлэгчид тулгамдаж буй асуудал, нөхцөл байдлаас хамааран аль бүлэгт хамаарахыг сонгоно уу:

1. Хөгжлийн бэрхшээлтэй  
2. Хүнд нөхцөлд байгаа  
3. Хүчирхийлэлд өртсөн  
4. Хорих ангиас суллагдсан  
5. Согтуурах, мансууруулах бодист донтсон  
6. Зан үйл нь эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдалд сэргээр нөлөөлж болзошгүй  
7. Гэр оронгүй, гэрээс дайжсан

8. Шилжин суурьшсан өрхийн гишүүн
  9. Өрх толгойлсон эцэг, эх
  10. Асрамж, халамжийн төвд амьдарч буй
  11. Насанд хүрээгүй эцэг эх болсон
  12. Сургууль завсардсан хүүхэд
  13. Бусад (нэрлэж бичнэ үү): \_\_\_\_\_
25. Өмнө нь хандаж байсан байгууллага
1. Өрхийн эрүүл мэндийн төв
  2. Сумын эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, эмнэлэг
  3. Хувийн эмнэлэг
  4. Хорооны нийгмийн ба халамжийн ажилтан
  5. Амьдарч буй сүм, дүүрэг
  6. Цагдаагийн газар, хэлтэс, албан хаагч
  7. Хүний эрхийн байгууллага
  8. Төрийн бус байгууллага
  9. Хаана ч хандаагүй
  10. Бусад (нэрлэж бичнэ үү): \_\_\_\_\_
26. Үйлчлүүлэгчид шаардлагатай тусламж үйлчилгээг сонгоно уу
1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн
  2. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих тусламж, үйлчилгээ
  3. Ахуйн хэрэглээний зүйлс, гэр/байр, хүнсний тусламж
  4. Хүүхэд, түүний гэр бүлийн хэрэгцээнд үндэслэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ
  5. Хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийг бичиг баримтжуулах
  6. Бусад (нэрлэж бичнэ үү): \_\_\_\_\_
27. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны үзүүлсэн үйлчилгээ
1. Аюулгүй байдлыг яаралтай хангах (хамгаалах байртай холбосон, хүргэсэн, байрлуулсан)
  2. Хүний эрхийг хамгаалах байгууллагатай холбох, зуучлах үйлчилгээ
  3. Хууль эрхэзүйн зөвлөгөө
  4. Сэтгэлзүйн зөвлөгөө
  5. Сэргээн засах үйлчилгээ эрүүл мэндийн, боловсролын, хөдөлмөр эрхлэлтийн, нийгэм-сэтгэлзүйн (эрүүл мэндийн, боловсролын, хөдөлмөр эрхлэлтийн, нийгэм-сэтгэлзүйн)
  6. Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ
  7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
  8. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих тусламж, үйлчилгээ

9. Хүний үндсэн хэрэгцээг хангах ахуйн хэрэглээний зүйлс, хоол хүнсний тусламж, үйлчилгээнд хамруулсан
10. Хүүхэд, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан
11. Хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийг бичиг баримтжуулах
12. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

28. Үйлчлүүлэгчийн асуудал шийдэгдсэн байдал (бичнэ үү)

.....

29. Холбоотой байгууллага, мэргэжилтний утасны дугаар (бичнэ үү):

30. Нийт зөвлөгөө өгсөн хүний тоо: \_\_\_\_\_

31. Гэр бүлийн ямар гишүүдэд зөвлөгөө өгсөн бэ? \_\_\_\_\_

### ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

1. Хүчирхийлэл үйлдэгч хэн болох:

1. Эцэг
2. Эх
3. Хойд аав
4. Хойд ээж
5. Танихгүй
6. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

2. Хүчирхийлэл эхэлсэн: \_\_\_\_ он \_\_ сар \_\_ өдөр

3. Өртсөн хүчирхийллийн хэлбэр:

1. Сэтгэл санааны
2. Бие махбодын
3. Бэлгийн
4. Үл хайхрах
5. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

4. Хамгийн сүүлд биө махбодид халдсан: \_\_\_\_ он \_\_ сар \_\_ өдөр

5. Хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл? .....

6. Ямар гэмтэл учирсан: .....

7. Гэр бүлийн бусад гишүүд хүчирхийлэлд өртдөг эсэх:      1.Тийм    2.Үгүй

Тийм бол гэр бүлийн ямар гишүүд хүчирхийлэлд өртдөг болохыг дэлгэрэнгүй бичнэ үү  
.....

8. Амиа хорлох бодол төрж байсан эсэх:                          1.Тийм    2.Үгүй

9. Хүчирхийлэл үйлдэгчийн овог: .....

10. Хүчирхийлэл үйлдэгчийн нэр: .....

11. Регистрийн дугаар:

12. Нас:

13. Хүйс:                          1. Эрэгтэй    2. Эмэгтэй

14. Үндсэн хаяг: Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_
15. Одоо оршин суугаа хаяг: Аймаг/хот \_\_\_\_\_ Сум/дүүрэг \_\_\_\_\_  
Баг/хороо \_\_\_\_\_
16. Холбоо барих утасны дугаар:
17. Хүчирхийлэл үйлдэгчийн мэргэжил: .....
18. Хүчирхийлэл үйлдэгчийн ажил эрхлэлт: .....
19. Хүчирхийлэл үйлдэгч архи, мансууруулах бодис хэрэглэдэг эсэх:  
1.Тийм 2.Үгүй 3.Мэдэхгүй
20. Хүчирхийлэгч эрүүл/согтуу/mansuursan ямар үедээ хүчирхийлэл үйлддэг вэ?  
1. Эрүүл 2.Согтуу 3. Согтуу/mansuursan
21. Хүчирхийлэлийн давтамж: ..... удаа
22. Хүчирхийлэлд өртсөн хүн энэ талаар хэн нэгэнд хандаж тусlamж, дэмжлэг авч байсан эсэх:  
1.Тийм 2.Үгүй  
Тийм бол хэнд хандаж байсан бэ?  
1. Эцэг, эх, асран хамгаалагч  
2. Өөрийн гэр бүлийнхэн  
3. Хүчирхийлэгчийн гэр бүлийнхэн  
4. Өөрийн найз нөхөд  
5. Багш  
6. Хамаатан  
7. Ажлын хүн, хамт олон  
8. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_
23. Үйлчлүүлэгчийн хүсэлт:  
1. Хуулийн байгууллагад хандах  
2. Хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусlamж, үйлчилгээний талаар мэдээлэл авах  
3. Нотлох баримт бүрдүүлэх, энэ талаар мэдээлэл авах  
4. Дэмжих бүлэгт хамрагдах  
5. Сэтгэлзүйн зөвлөгөө  
6. Хууль эрхэзүйн зөвлөгөө  
7. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авах  
8. Боловсролын байгууллагатай холбоотой зөвлөгөө, мэдээлэл  
9. Аюулгүй байдлаа хамгаалуулах  
10. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_
24. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны үзүүлсэн үйлчилгээ (бичнэ үү):  
.....

## УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ

1. Үзлэг эхэлсэн: \_\_\_\_ он \_\_ сар \_\_ өдөр
2. Нас \_\_\_\_
3. Хүйс:            1. Эрэгтэй      2. Эмэгтэй      3. Бусад
4. Онош:            1. Эрүүл          2. Өвчин илэрсэн  
Өвчин, эмгэг илрүүлсэн бол онош (дэлгэрэнгүй эсвэл олон улсын өвний ангиллын кодоор бичих): \_\_\_\_\_

## ЗӨВЛӨГӨӨ АВАГЧДЫН БҮРТГЭЛ

1. Зөвлөгөө өгсөн: \_\_\_\_ он \_\_ сар \_\_ өдөр
2. Нас \_\_\_\_
3. Хүйс:            1. Эрэгтэй      2. Эмэгтэй
4. Зөвлөгөөний төрөл:
  1. Гэр бүл төлөвлөлт
  2. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл
  3. Үерхэл, нөхөрлөл
  4. Сэтгэлзүйн тулгамдсан асуудал
  5. Бэлгийн боловсрол
  6. Бэлгийн чиг баримжaa
  7. Бэлгийн замаар дамжих халдвар
  8. Эрүүл амьдралын хэв маяг
  9. Жирэмслэлт, шийдвэр гаргах, үр хөндөлт, жирэмсний хяналт
  10. Арьсны асуудал, эмчилгээ, арьс арчилгаа
  11. Бусад (нэрлэж бичнэ үү) \_\_\_\_\_

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 10-р сарын 26-өдрийн тогтоот  
тушаалын тавдугаар хавсралт

## ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДТЭЙ ХОЛБООТОЙ НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТАЙЛБАР

### Нэг. Ерөнхий нэр томъёо

1. Үндсэн өвчин буюу онош:

Үйлчлүүлэгчийг эмчилгээ, оношлогоо хийлгэхэд хүргэсэн төгсгөлийн онош юм. Хэрэв ийм өвчин, эмгэг нэгээс олон илэрсэн бол хамгийн их зардал гаргасныг нь үндсэн өвчнөөр сонгож авна. (Өвчний олон улсын ангилал, гарын авлага, 2-р боть, ДЭМБ, 110-р хуудас)

2. Хавсарсан өвчин:

Тухайн үед өвчтөнд байгаа үндсэн өвчинтэй холбоогүй боловч өвчтөнд байгаа нозологийн хувьд өөр өвчнийг хэлнэ. (Эрүүл мэндийн технологи, эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд, MNS 4621-98, 2008)

3. Хүндрэл:

Үндсэн өвчинтэй шалтгаан эмгэг жамаар холбоотой гараад түүнээс чанарын ялгаа бүхий эмнэлзүйн илрэл, бүтэц судлалын болон үйлийн өөрчлөлт үзүүлж үхлийн шалтгаан болсон эмгэг буюу хам шинжийг хэлнэ. (Эрүүл мэндийн технологи, эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд, MNS 4621-98, 2008).

### Хоёр. Өсвөр үеийн эрүүл мэнд

1. Тодорхойлолт: Өсвөр нас (adolescere буюу өсөж том болох гэсэн латин үгнээс гаралтай) биологийн хувьд бэлгийн бойжилтоор тодорхойлогддог бөгөөд энэ нь нийгмийн асуудал гэж тооцогдон, охин болон хөвгүүн гэр бүлээсээ бие даасан байдалтай болж насанд хүрч байгааг хэлнэ. (Өсвөр үеийн эрүүл мэндийн баримжаа олгох сургалтын удирдамж, ЭМЯ, 2013 он)
2. Өсвөр нас: 10-19 насыг хамарна. (ДЭМБ)
3. Залуучууд: 15-24 насыг хамарна. (ДЭМБ)
4. Залуу хүмүүс: 10-24 насыг хамарна. (ДЭМБ)
5. Нийгмийн ажилтан: Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтан; (2016 оны 2-р сарын 5, Хүүхэд хамгааллын тухай хууль, 4-р зүйл)
6. Өсвөр үеийн эмч: өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн эмч (2017 оны 10-р сарын 17-ны ЭМС-ын A399 тоот тушаал, 2 дугаар бүлэг)
7. Өсвөр үед ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ: өсвөр үеийнхэнд зориулсан чанартай, чирэгдэлгүй, тохиромжтой, хүртээмжтэй, нууцлалыг хангасан эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ (2017 оны 10-р сарын 17-ны ЭМС-ын A399 тоот тушаал, 2 дугаар бүлэг)
8. Үйлчлэх хүрээний хүн ам: кабинетийн байрлаж буй нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин сууж буй өсвөр үеийнхэн, залуучуудыг хэлнэ. (2017 оны 10-р сарын 17-ны ЭМС-ын A399 тоот тушаал, 2 дугаар бүлэг)
9. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл: Санаятай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах

байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт. (2016 оны 2-р сарын 5, Хүүхэд хамгааллын тухай хууль, 4-р зүйл)

10. Гэр бүлийн хүчирхийлэл: хуулийн 3 дугаар зүйлд (3.1.1. эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд; 3.1.2. тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү. 3.2. Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.) заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй; (2016 оны 12-р сарын 22, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5-р зүйл)
11. Бэлгийн замаар дамжих халдвартай: Халдвартай хүнээс ихэвчлэн бэлгийн хавьтлын үед дамжин халдварлаж, шээс бэлгийн замын эрхтэнг гэмтээхийн зэрэгцээ бусад эрхтэн тогтолцоонд ч нөлөөлдөг бүлэг өвчин. (2017 оны 8-р сарын 3-ны ЭМС-ын А305 тоот тушаал, 2 дугаар хавсралт)
12. Бэлгийн замаар дамжих халдварын үүсгэгчид: Бэлгийн замаар дамжих халдвар нь нян (Treponema pallidum, Neisseria gonorrhoeae, Chlamydia trachomatis, M.genitalium, Haemophilus Ducreyi), эгэл биетэн (Trichomonas vaginalis), вирус (Retrovirus, Herpes simplex virus, Human papilloma virus), мөөг (Candida) зэрэг бичил биетнээр үүсгэгдэнэ. (2017 оны 8-р сарын 3-ны ЭМС-ын А305 тоот тушаал, 2 дугаар хавсралт)
13. Эрсдэлт зан үйл: Халдвар авч өвчлөх эрсдэлд хүргэж буй зан үйл (2017 оны 8-р сарын 3-ны ЭМС-ын А305 тоот тушаал, 2 дугаар хавсралт)
14. Бэлгийн замаар дамжих халдварын эрсдэлт зан үйл: Бэлгийн замаар дамжих халдварт өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх зан үйл (2017 оны 8-р сарын 3-ны ЭМС-ын А305 тоот тушаал, 2 дугаар хавсралт)
15. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал: нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдал; (2016 оны 4-р сарын 22, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, 3-р зүйл)
16. Үр зулбалт:  
Жирэмсний 22 долоо хоногийн дотор зориудаар юмуу өөрөө аяндаа үр хөврөл, ураг умайгаас гарах. Үр зулбалтын үе шат:
  - Тулгарсан зулбалт (жирэмслэлт үргэлжилж болно)
  - Өсөлтгүй жирэмсэн (жирэмслэлт үргэлжлэхгүйгээр дутуу эсвэл бүрэн зулбалтад хүрнэ).
  - Дутуу буюу бүрэн бус зулбалт (эдийн хэсэг зулбаж гарна)
  - Бүрэн зулбалт (эд бүрэн зулбаж гарсан байна) (ДЭМБ, "Жирэмсэлт, төрлөгийн хүндрэлийг удирдах аргазүй" удирдамж, 2007, S-1 хайрцаг)
17. Үр хөндөлт:  
Жирэмснийг эмнэлгийн аргаар таслах ажилбар. (ДЭМБ, "Жирэмсэлт, төрлөгийн хүндрэлийг удирдах аргазүй" удирдамж, 2007, S-1 хайрцаг)
18. Эрт үеийн үр хөндөлт:  
Жирэмсний эхний 12 долоо хоног дотор үр хөврөлийг авах ажилбар. ("Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ" MNS 5488:2005)
19. Хожуу үеийн үр хөндөлт:  
Жирэмсний 13 долоо хоногоос 22 долоо хоногийн дотор жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах ажилбар. ("Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ" MNS 5488:2005)
20. Аюултай үр хөндөлт:

Стандартын шаардлага хангаагүй орчинд эсвэл ур чадвар эзэмшээгүй, уг ажилбарыг хийх эрхгүй хүн үр хөндөлт хийх. (ДЭМБ, "Жирэмсэлт, төрлөгийн хүндрэлийг удирдах аргазүй" удирдамж, 2007, S-1 хайрцаг)

21. Бэлгийн бойжилтын хэвийн үе шатууд (Таннерийн үе шатаар)

Хөвгүүдэд			
Үе шат	Бэлэг эрхтэн	Умдагны үсжилт	Бусад өөрчлөлт
I	Бэлгийн бойжилтын өмнөх	Цөөн тооны, шингэн	TX*<4 мл
II	Төмсөг ба хуйхнагны томрол	Цөөн тооны урт үс	TX 4-8 мл шодойн уг хэсгээр ургасан, дуу хоолой өөрчлөгджэх эхэлсэн
III	Шодой уртсах	Илүү бараан, өтгөн үс	TX 8-10 мл Умдаг хэсгээр тархсан Суганы үс ургах
IV	Шодой уртсахын зэрэгцээ өргөснө гэхдээ бага хэмжээтэй	Үсжилт насанд хүрэгсэдтэй ижил	TX 10-15 мл Өсөлтийн хурд дээд хэмжээнд хүрэх ба сахал ургана
V	Насанд хүрсэн хэлбэр	Гуя, хэвлэлийн цагаан шугам руу тархсан	TX 15-25 мл Сахал нүүрээр тархах ба дуу хоолой бүдүүрнэ

Охидод			
Үе шат	Хөхний хөгжил	Умдагны үсжилт	Бусад өөрчлөлт
I	Хөхний товч ялимгүй овойх	Цөөн тооны, шингэн	
II	Хөхний хөгжил эхлэх: Хөхний товч булчирхайлаг эд түрэх	Цөөн тооны урт нэсөөжилттэй үс умдагны урд хэсэгт хүрэх	Өсөлтийн хурд дээд хэмжээнд
III	Хөх цаашид булчирхайлаг ба товч хэсгээрээ нэмж томрох тархах	Илүү өтгөн хар, нэсөөжилттэй үс умдагт	Суганы үс ургах
IV	Хөхний товч булчирхайлаг хэсгийн дээр хоёр дахь давхрааг үүсгэх гагцхүү бага хэсгийг хамарсан	Үсжилт насанд хүрэгсэдтэй ижил	Анхны биений юм ирэх
V	Насанд хүрэх шат: Хөхний товч ба булчирхайлаг хэсэг бүрэн хэлбэржсэн,	Гуя, хэвлэлийн цагаан шугамаар тархсан	

TX\*- төмсөгний хэмжээ. Хэмжилтийг Прадерийн орхидометр буюу төмсөг хэмжигчтэй харьцуулав.

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны ... сарын ... өдрийн ... тоот  
тушаалын зургаадугаар хавсралт

## ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

